

ИРГЭДЭЭС ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД
ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААРХ 2018 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН МЭДЭЭНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2018.12.28

Арвайхээр хот

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхдээ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2008 оны 44 дүгээр захирамжаар батлагдсан “Иргэдээс аймаг, сумын Засаг дарга, түүний Тамгын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх хэлтэс албадад гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх тухай журам”-ыг мөрдлөг болгон иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчлэх зарчим баримтлан ажиллаж байна.

“Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв”-д 2018 оны 4 дүгээр улиралд нийт 48 иргэн хандсанаас санал-22, гомдол-22, талархал-4 тус тус ирсэн байна. Ирсэн гомдлуудыг холбогдох байгууллагад уламжилж хуулийн хугацаанд шийдвэрлээд байна.

Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн 70321111 дугаарын утсанд нийт 1473 өргөдөл, гомдол, санал ирснээс 1471 буюу 98.8 хувь нь хуулинд заасан хугацаанд шийдвэрлэгдсэн байна. Ирсэн өргөдөл, гомдол, саналын 313 нь мэдээлэл, тодруулга, 989 гомдол, 171 санал байна.

Долоо хоног бүрийн Мягмар гаригт хуралддаг аймгийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлаг, албадын дарга нарын “Шуурхай хуралдаан”-ыг 47 удаа зохион байгуулж, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх талаар байгууллагын удирдлагуудад хугацаатай үүрэг даалгавар өгч, 7032-1111 утсанд иргэдийн ирүүлсэн санал, гомдлыг шийдвэрлэх талаар 47 удаагийн мэдээллийг сонсч, шийдвэрлэлт, хариу өгсөн байдалд дүгнэлт хийж, төрийн үйлчилгээг шуурхай хүргэхэд анхаарч ажиллалаа.

2018 онд Хархорин, Есөнзүйл, Хайрхандулаан, Нарийнтээл сумдын Засаг даргын Тамгын газар болон төсөвт байгууллагууд, мөн аймгийн Засаг даргын дэргэдэх 21 агентлагын өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан албан тушаалтнуудад сургалт хийж, арга зүйн зөвөлгөө өгч ажиллалаа.

2018 оны жилийн эцсийн байдлаар аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон хэлтэс, албадууд, төсөвт байгууллага, ажилтанд нийт 22627 өргөдөл, гомдол, санал ирүүлсэн байна. Үүнээс өргөдөл 20225 буюу 89.4 хувь, гомдол 1883 буюу 8.3 хувь, санал 519 буюу 2.3 хувийг тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд нийт 22627 өргөдөл, гомдол, санал ирсэний 378 буюу 1.7 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй, 22249 буюу 98.3 хувь нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна.

Ирсэн өргөдөл, гомдлыг агуулгын хувьд авч үзэхэд, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, газар өмчлөх, эзэмших хүсэлт, иргэний бичиг баримтын зөрчил арилгуулах, байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой 18883 буюу 83.4 хувь, материал, мөнгөн тусламж хүссэн 1448 буюу 6.4 хувь, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой, 533 буюу 2.4 хувийг тус тус эзэлж байна.

Иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг 2018 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн гаргаж, хавсралтаар хүргүүлээ.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАРТ

Өвөрхангай аймгийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтнуудад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг 2018 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн гаргаж, танилцуулгын хамт хавсралтаар хүргүүлэв.

Жич: Хавсралт хуудастай.

ДАРГА

Ц.ГАНБОЛД

ИРГЭДЭЭС ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

2018.12.28

Арвайхээр

д/д	Байгууллагын нэр	Нийт өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт			Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт /Хувь/
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн		
1	Аймгийн ЗДТГазар	357	345	115	-	12	96.6 %
2	Агентлагууд	1240	1118	19	21	122	90.2 %
3	Сумд	19557	19315	2796	-	242	98.7 %
4	Аймгийн Мэдээлэл, шуурхай удирдлагын төв /703211111/	1473	1471	1473	10	2	99.8 %
Дүн		22627	22249	4403	31	378	98.3%

НЭГТГЭСЭН:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

П.МӨНХЗУЛ

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА

Ц.ГАНБОЛД

ИРГЭДЭЭС ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ /ХЭЛБЭРЭЭР/

2018.12.28

Арвайхээр

д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт	Үүнээс:						
			Бичгээр	Засгийн газрын 11-11 төвд ирсэн	Аймгийн МШУТөв, 7032-1111	Цахимаар	Утсаар	Биечлэн	Бусад
1	Аймгийн ЗДТГазар	357	309	48	-	-	-	-	-
2	Агентлагууд	1240	953	3	140	-	21	123	-
3	Сумд	19557	17091	-	348	-	258	1625	235
4	Аймгийн Мэдээлэл, шуурхай удирдлагын төв /70321111/	1473	30	-	-	-	1443	-	-
Дүн		22627	18383	51	488	0	1722	1748	235
Хувь		100	81.2	0.2	2.2	0.0	7.6	7.7	1.0

НЭГТГЭСЭН:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН П.МӨНХЗУЛ

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА

Ц.ГАНБОЛД

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТИЙН АГУУЛГА /ХУВИАР/

2018.12.28

Арвайхээр

Аймгийн нэр	/тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/			
Өвөрхангай аймаг	Нийт өргөдөл, гомдол, санал 22627 ирсэн байна.	хүсэлт	20225	89.3 %
		гомдол	1883	8.3 %
		санал	519	2.2 %
	Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, газар өмчлөх, эзэмших хүсэлт, иргэний бичиг баримтын зөрчил арилгуулах, нийгмийн даатгалт, байгууллагын үйлчилгээ үйл ажиллагаатай холбоотой асуудлууд	18883	83.4 %	
	Материал, мөнгөн тусламж хүссэн	1448	6.3 %	
	Ажилд орох, чөлөөлүүлэх	1109	4.9 %	
	Шилжилт хөдөлгөөн	533	2.3 %	
	Тэтгэвэр тогтоолгох	357	1.5 %	
	Гэр, орон сууц хүссэн	203	0.8 %	
	Сургууль, курст суралцах	94	0.4 %	
	<ul style="list-style-type: none"> • Аймгийн Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн 70321111 утсанд 1473 иргэн хандсанаас 989 иргэний гомдлыг шийдвэрлэж, цаг үеийн шинжтэй мэдээллийг 313 иргэнд өгч, 171 санал ирсэн байна. • Уянга-3687, Арвайхээр-2311, Хархорин-1528 өргөдөл тус тус ирсэн байгаа нь өрх, хүн амын тоо их байгаатай холбоотой байна. 			

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР